



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

### Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхчүүд, багш ажилчдаас хандивласан нийт 19,110,000.00 (арван есөн сая нэг зуун арван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг (Ц.Мөнхжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг (Ц.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150501021

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2024 оны 09 дүгээр сарын 03-ийн  
 өдрийн А/09/С-рөөт тушаалын хавсралт



Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Хандив
						Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1.Тавилга эд хогшил								
1	Хивс	2024	сайн	м	6	300,000.00	1,800,000.00	Хандив
2	Хивсэнцэр	2024	сайн	м	64.3	200,000.00	12,860,000.00	Эцэг эхчүүд
Тавилга эд хогшлын дүн							14,660,000.00	хандив
2. Тоног төхөөрөмж								
1	Принтер ерсон L3158	2024	сайн	ш	1	450,000.00	450,000.00	багш ажилчид, ахмад ажилтан хандив
2	Оёдлын машин Juki	2024	сайн	ш	1	2,500,000.00	2,500,000.00	
3	Хэрээсний машин Jask	2024	сайн	ш	1	950,000.00	950,000.00	
4	Халуунаар үлээгч тенг	2024	сайн	ш	1	550,000.00	550,000.00	
Тоног төхөөрөмжийн нийт дүн							4,450,000.00	
<b>Бүртгэх хөрөнгийн нийт дүн</b>							<b>19,110,000.00</b>	